

## **Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) ОУБ-аас улс төрийн намууд болон нэр дэвшигчдэд хандаж “Авлигыг устгахын тулд Монгол Улс хэвлэл мэдээллийн салбартаа шинэтгэл хийх шаардлагатай” гэв**

**Энэ сарын 24-нд болох сонгуулиас урьтаж Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) олон улсын байгууллагаас нийт нэр дэвшигч, улс төрийн намуудад хандан хэвлэлийн эрх чөлөөний төлөө дуу хоолойгоо илэрхийлэхийг уриалж байна. Мөн сонгогдсон даруйдаа авлигыг таслан зогсоох хамгийн шилдэг арга гэдэг утгаар нь ёс зүйт сэтгүүл зүйн төлөөх шинэтгэлд түлхэц үзүүлэхийг хүсч байна.**

Монгол Улсыг тахал мэт нөмөрсөн дотоод дахь авлигын асуудлыг эсэргүүцэж 20 мянга гаруй иргэн 2019 оны нэгдүгээр сард буюу өвлийн тэсгим хүйтэнд Улаанбаатарын төв талбайд жагссан билээ. Хууль тогтоох байгууллагын төлөөллийг сонгох өдөр ойртож буйтай холбогдуулан Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) сэтгүүл зүйн төлөөх олон улсын төрийн бус байгууллага нь чөлөөт, хараат бус хэвлэл мэдээллийн салбар бол авлигыг илчлэх үндсэн капитал гэдгийг онцолж байна. Үүний зэрэгцээ, Монгол Улсад ёс зүйт сэтгүүл зүйн туршлагыг түгээн дэлгэрүүлэхийн тулд шинэтгэл хийхэд түлхэц үзүүлэхийг нийт нэр дэвшигч, улс төрийн намуудад сануулах нь зүйтэй.

Цагдан хяналт, суртал ухуулгыг өргөн хүрээтэй явуулдгаараа зартай дэлхийн хүчирхэг хоёр гүрэн болох Орос, Хятадын завсар оршдог хэдий ч, Монгол Улс нь эрч хүчээр дүүрэн ардчилсан нийгмийг бүтээснээр хэвлэл мэдээллийн салбар нь өсөн дэвшиж байна. Гуравхан сая хүн амд 500 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 5000 орчим сэтгүүлч ногдож буй нь үүнийг илтгэж байна. Гэвч эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь хувийн эсвэл олон нийтийн гэх эзэмшлээсээ үл хамааран улс төр, эдийн засгийн хүчтэй дарамтын дор хэвээр байгаа ба учир дутагдалтай хууль эрх зүйн зохицуулалтын улмаас хохирч байна. Иймээс Монгол Улсын хувьд RSF-ийн Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний индекст мэдэгдэхүйц ахиц үзүүлээгүй бөгөөд 2002 онтой адил буюу 180 орноос 73 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Монголын дийлэнх сэтгүүлчид дараах үндсэн бэрхшээлтэй тулгарч байна. Үүнд: өөрийн цензурыг бий болгож, сэтгүүлчдэд өндөр хэмжээний торгууль ногдуулахад хүргэж буй гүтгэлгийн эсрэг хууль тогтоомж бөгөөд уг асуудал хэвлэлийн мэдээллийн салбарын эсэргүүцэлтэй тулгарч, 2017 онд телевизийн сувгууд орон даяар эфирээ хааж байв. Энэ жилийн нэгдүгээр сард орсон нэмэлт өөрчлөлтөөр “хуурамч мэдээлэл” түгээхийг эрүүгийн гэмт хэрэгт тооцох болсон нь өөрийн цензурыг улам гааруулав. Нэрээ нууцлахыг хүссэн эх сурвалжийг хамгаалах хуулийн зохицуулалт байхгүйн улмаас шүгэл үлээгчид идэвхгүй болов. Мөн редакцийн хараат бус байдлыг хангах хуулийн хэрэгжилт дутмаг байна. Хэдийгээр 2019 оны арванхоёрдугаар сард өргөн нэвтрүүлэг эрхлэгчдийн эзэмшлийг олон нийтэд ил тод болгох хууль санаачлан баталсан нь сайшаалтай хэдий ч, энэ нь ашиг сонирхлын зөрчлөөс үүдэлтэй системийн хэмжээний асуудлыг шийдэхэд хангалтгүй.

2020-06-02

Хэвлэл мэдээллийн эздийн хувьд “хэвлэлийн эрх чөлөөний” зарчмыг өөрсдийн ашиг сонирхолд нийцсэн мэдээ, мэдээллийг чөлөөтэй түгээхэд урвуулан ашиглаж хэрхэвч болохгүй. Хэвлэлийн эрх чөлөө нь бүрэн хэмжээнд хүчин төгөлдөр үйлчлэхийн тулд яг л бусад эрх чөлөөний адил зөв зохицуулалт, ардчилсан хяналтыг заавал шаардаж байдаг. Мэдээний хараат бус, олон ургальч, найдвартай байдлыг хөхиүлэн дэмжихийн тулд НҮБ-ын Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлээр баталгаажуулсан үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөг хамгаалах тогтолцоо шаардлагатай байна.

Үүнтэй холбогдуулан Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) байгууллагаас Монголын парламентад суудал гориллогч нэр дэвшигч, улс төрийн намуудад хандан дараах таван чиглэлээр шинэтгэл хийхэд дэмжлэг үзүүлэхийг уриалж байна. Үүнд:

1) хэвлэл мэдээллийн эзэмшлийн ил тод байдал, редакцийн хараат бус байдлыг бэхжүүлэх; 2) сэтгүүлч, түүний эх сурвалжийг шүүх, биет болон цахим зэрэг аливаа хэлбэрийн дарамтаас үр дүнтэйгээр хамгаалах; 3) олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөөц бололцоог эрс нэмэгдүүлж, бие даасан байдлыг нь баталгаажуулах; 4) хуурамч мэдээллийн эсрэг процесс нь гүйцэтгэх засаглалаас ангид хараат бус, ил тод байдлаар бий болгох; 5) хэвлэл мэдээллийг танин мэдэх эрдмийг боловсролын тогтолцооны салшгүй хэсэг болгох.

Энэхүү шинэтгэл нь улс төрийн үзэл баримтлалын зөрчлөөс дээгүүр тавигдах ёстой бөгөөд шинэчлэх явцад хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулбал зохино. Ингэхдээ, Мэдээлэл ба ардчиллын форумас гаргасан удирдамж болон Сэтгүүл зүйн итгэлийн санаачилгаас (ITI) тогтоосон стандартыг дагахыг зөвлөж байна. Дээр дурдсан хоёр хөтөлбөрийн тухайд, сэтгүүл зүйн хэм хэмжээ, ёс зүйг өргөжүүлэн тэлэх, дэлхий дахинаа мэдээллийг чөлөөтэй нэвтрүүлэн түгээх үйлсийг хөхиүлэн дэмжих зорилгын хүрээнд Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) байгууллагаас санаачилсан билээ.

Ийнхүү шинэтгэл явуулснаар Монгол Улс нь авлигын эсрэг үр дүнтэйгээр тэмцэж чадна гэдэгт бид итгэлтэй байна. Сэтгүүлчид нь залхаан цээрлүүлэх шинжтэй гүтгэлгийн заргаас ангид байж, редакциуд нь ямарваа улс төр, эдийн засгийн дарамт, шахалтаас хамааралгүйгээр үйл ажиллагаа явуулах боломж бүрдсэн цагт авлига буурна.

Хэвлэл мэдээллийн орчноо улам сайжруулах замаар ардчилсан тогтолцоог бэхжүүлэх уг боломжийг Монгол Улс нааштайгаар хүлээн авч, олон улсын тавцан дахь нэр хүндээ улам өндөрт өргөсөөр явна гэдэгт бид гүнээ итгэж байна

**Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF)**  
**Зүүн Ази хариуцсан товчооны захирал**  
**Седрик Алвиани**